




ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙСЭН ДАЛАНЗАДГАД СУМЫН УС ЗАЙЛУУЛАХ ШУГАМ, ДАЛАН, ШУУДУУ БАЙГУУЛАХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ДҮГНЭЛТ ГАРГАХ ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 4 дугаар сарын 11-ны өдөр Дугаар УАГ-АД/2025-14 Даланзадгад сум

Ажлын зорилго:
Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийх гүйцэтгэлийн аудитын хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулсан байгууламжийн ажлын гүйцэтгэл нь Монгол Улсын хууль тогтоомж, барилга, байгууламжийн норм, дүрэм, стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.

Ажил гүйцэтгэх хугацаа:
Эхлэх хугацаа: 2025 оны 04 дүгээр сарын 15 -ний өдөр
Дуусах хугацаа: 2025 оны 06 дугаар сарын 10 -ний өдөр

Байршил: Өмнөговь аймаг Даланзадгад сум

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Даланзадгад сумын үерийн гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор хийсэн ус зайлуулах шугам, далан шуудуу байгуулах ажил нь 28,998.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ба 2024 оны жилийн эцсийн байдлаар 9,044.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т заасны дагуу тавигдах шаардлагад заасан мэргэжлийн тусгай мэдлэг, үр чадвар бүхий этгээдийг шинжээчээр аудитад татан оролцуулна.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ ҮҮРЭГ

Шинжээч нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн дараах байгууламжийн ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргах ажлыг хэрэгжүүлнэ. Үүнд:

д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	Үерийн ус зайлуулах хамгаалалтын далангийн зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангасан эсэхэд шинжээчийн дүгнэлт гаргах;	Төсвийн тухай хууль, Барилгын тухай хуулийн 4.1.1 Авто замын тухай хууль, Зам, замын байгууламжийн ажлын жишиг техникийн шаардлага, холбогдох бусад хууль, журам, стандарт	Орон төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга байгууламжийн зураг төслийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар	✓ Тооцоо судалгаа, шаардлагад үндэслэн төлөвлөсөн байх; ✓ Холбогдох байгууллагуудаас техникийн нөхцөл, бусад зөвшөөрлийг авсан байх; ✓ Зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангасан байх; ✓ Зурагт магадлал хийж, дүгнэлт гаргасан байх

2	Үерийн усны хамгаалалтын ажлын төсвийг батлагдсан зургийг үндэслэн холбогдох хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиосон эсэхэд дүгнэлт гаргах;	БХБС, ЗТХСайдын тушаалаар баталсан зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам, холбогдох бусад хууль, норм дүрэм стандарт	төлөвлөж, ажлын гүйцэтгэл нь Монгол Улсын хууль тогтоомж, барилга, байгууламжийн норм, дүрэм, стандартын шаардлагад нийцэж, үр нөлөө, үр дүн бий болсон эсэхэд дүгнэлт гаргахад оршино.	✓ Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага гүйцэтгэсэн байх; ✓ Хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиосон байх; ✓ Төсөвт магадлал хийж, дүгнэлт гаргасан байх;
3	Барилга байгууламжийн ажил нь магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэгдсэн эсэхэд дүгнэлт гаргах;	Батлагдсан зураг, төсөл, норм нормативын баримт бичиг, холбогдох бусад хууль, журам, стандарт		✓ Хөрсний бодит байдал инженер геологийн дүгнэлттэй нийцсэн байх; ✓ Шороон далан суурь, хөвөөний ажил, бусад байгууламжууд, тоноглол, тэмдэг, тэмдэглэгээний ажил тус бүрийг зураг, төсөв, норм, стандартын дагуу гүйцэтгэсэн байх; ✓ Барилга байгууламжийн ажилд ашигласан материал нь чанарын шаардлага хангасан байх;
4	Үерийн усны хамгаалалтын байгууламжийн үе шатны ажлуудад хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байдал, өгсөн зааварчилгаа, түүнийг хэрэгжүүлж ажилласан байдлыг нягтлан шалгаж, дүгнэлт гаргах;	Барилга байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам, холбогдох бусад хууль, журам, стандарт		✓ Үерийн усны хамгаалалтын байгууламжийн ажилд хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагатай хяналтын, гэрээ байгуулсан байх, ✓ Гүйцэтгэгчийн дотоод хяналтыг өдөр тутам гүйцэтгэж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгасан байх; ✓ Эрх бүхий байгууллагаас барилга байгууламжийн ажилд үе шатны болон өдөр тутмын хяналт гүйцэтгэсэн байх; ✓ Ил, далд ажлын актыг үнэн зөв, бүрэн баталгаажуулсан байх, ✓ Бүх төрлийн хяналтын зардал, норм нормативын санг зориулалтын дагуу зарцуулсан байх;
5	Үерийн усны хамгаалалтын байгууламжийн ашиглалтад оруулах техникийн болон улсын комисс ажилласан байдал, тэдгээрээс өгсөн үүрэг даалгавар хэрэгжсэн эсэхэд дүгнэлт гаргах;	Барилга байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам холбогдох бусад хууль, журам, стандарт		✓ Үерийн усны хамгаалалтын байгууламжийн ашиглалтад оруулах техникийн болон улсын комиссыг хууль, журмын дагуу томилж ажиллуулсан байх; ✓ Комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгавар бүрэн хэрэгжсэн байх; ✓ Барилга байгууламжийн зураг төсөл, барилга байгууламжийн гүйцэтгэлийн болон хяналтын бүх баримт материалуудыг архивын нэгж болгосон байх,

6	Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад орц, материалын тоо хэмжээ, нэр төрөл, чанар, агууламж зэргийг хянаж, батлагдсан төсөв болон бодит гүйцэтгэл, олгосон санхүүжилтийн хооронд зөрүү илэрсэн тохиолдолд гүйцэтгэлийн өртөгт үзүүлэх нөлөөллийг тогтоож, төсөвт гарсан хэмнэлт, хэтрэлтийг тоо хэмжээ болон үнийн дүнгээр гаргах.	Барилга байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм, барилга байгууламжийн ажлын төсөв, холбогдох бусад хууль, журам, стандарт		✓ Үерийн усны хамгаалалтын байгууламжийн орц, материалын тоо хэмжээ, нэр төрөл, чанарын гүйцэтгэл нь батлагдсан төсөвтэй дүйцэж байх; ✓ Магадалшгүй ажил, захиалагчийн хяналтын зардлын хэтрэлт, хэмнэлтийг тооцож, бодит гүйцэтгэлээр санхүүжүүлсэн байх; ✓ Гүйцэтгэгч нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбоотой бүх төрлийн төлбөр, хураамжийг улс, орон нутгийн төсөвт зүй ёстоор төвлөрүүлсэн байх.
---	---	---	--	---

ГУРАВ. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд Даланзадгад суманд үерийн гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор хийсэн ус зайлуулах шугам, далан шуудуу байгуулах ажил

№	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хэрэгжих хугацаа		Байгуулсан гэрээний дүн /Төгрөг/	Нийт төсөвт өртөг /Төгрөг/
			Эхлэх	Дуусах		
1	Өмнөговь аймгийн Засаг дарга	Даланзадгад сумын үерийн ус зайлуулах шугам, сүлжээний зураг төсөл	2021	2022	99,971,007	28,998,800,000
2		Даланзадгад сумын үерийн гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор ус зайлуулах шугам, далан, шуудуу байгуулах	2023	2024	3,795,732,595	
3		Даланзадгад сумын үерийн гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор ус зайлуулах шугам, далан, шуудуу байгуулах багц-1	2024	2025	4,196,366,544	
4		Даланзадгад сумын үерийн гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор ус зайлуулах шугам, далан, шуудуу байгуулах багц-2	2024	2024	4,990,937,572	

ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Ажлын гүйцэтгэлээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Шинжээч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажлын даалгаварт заасан ажилбаруудыг төсөл, арга хэмжээ бүрээр, чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, тоног төхөөрөмж, барилга, байгууламжийн ажлын гүйцэтгэл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, норм, норматив, стандартаар тавигдах бусад шаардлагуудтай нийцсэн эсэх, барилга, байгууламжийг техникийн шаардлагын дагуу барьж ашиглалтад оруулсан эсэхийг хянан үзэж, гарсан үр дүн, үр нөлөөг тусгасан мэргэжлийн дүгнэлт бүхий тайланг бэлтгэнэ.

• Шинжээчийн ажил гүйцэтгэх явцад нийлүүлсэн тоног төхөөрөмж, барилга байгууламжийн гүйцэтгэлд илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагаварт хийсэн дүн шинжилгээ, дүгнэлтээс гадна илэрсэн зөрчлийг арилгах, тулгарсан асуудлыг шийдвэрлэх боломжийн талаар зөвлөмж, санал боловсруулж, тайланд тусгана.

• Шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох баримт, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

ТАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гүйцэтгэх ажил үүргийн хүрээнд ажиллах иргэн, хуулийн этгээд нь /цаашид “шинжээч” гэх/ “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн Даланзадгад сумын ус зайлуулах шугам, далан, шуудуу байгуулах” ажлыг гүйцэтгэх Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн аудитын багийн бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллана.

Тус ажлыг ажлын даалгаврын дагуу гүйцэтгэхээр шалгарсан хуулийн этгээд/хувь хүн/баг нь захиалагч Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, аудитын багтай уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллаж болно.

Үе шатны ажлын явцад бий болсон шийдвэрлэх боломжгүй асуудлыг тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд мэдэгдэж, хамтарч ажиллана.

ЗУРГАА. ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН АЖЛЫН ТУРШЛАГА

Шинжээч нь тухайн аудитад оролцоход ашиг сонирхлын зөрчилгүй, хувь хүн, байгууллага, албаны болон төрийн нууцыг задруулахгүй гэдгээ бүрэн илэрхийлж, Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Тавигдах шаардлагын хүрээнд ажиллахад дараах шаардлага тавигдана. Үүнд:

Хуулийн этгээдийн хувьд:

- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхтэй байх,
- Орон тооны мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй байх,
- Татвар, Нийгмийн даатгалын өр төлбөргүй байх,
- Гүйцэтгэсэн адил төстэй 5- аас доошгүй үйлчилгээ үзүүлсэн байх

Баг, хувь хүний хувьд:

Багийн ахлагч:

- Усны барилга байгууламжийн инженер Монгол Улсын зөвлөх инженер, магистр буюу түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил ажилласан байх;

Багийн гишүүд:

- Барилга, ус хангамж, ариутгах татуургын инженер, тэргүүлэх төсөвчин, мэргэшсэн инженер, мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан, судалгаа шинжилгээний болон шинжээчийн 3-аас доошгүй ажлын туршлагатай байх.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

ДОЛОО. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Шинжээчийн ажлын хөлсийг харилцан тохиролцож гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу олгоно.

ХЯНАСАН:

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ӨСӨХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Т.ХОНГОРЗУЛ

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Г.ШИЖИРБОЛД

Э.ЖАМЦДОРЖ